



БАЯНХОНГОР АЙМАГТ 2022 ОНЫ 3 ДУГААР САРД БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

2022 оны 04 дүгээр сарын 01

Номгон

НЭГ: ХҮЛЭЭН АВЧ ШАЛГАСАН ГОМДОЛ, МЭДЭЭЛЭЛ

1.1. Тус цагдаагийн газар нь 2022 оны 3 сард иргэн, аж ахуйн нэгжээс гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй 1258 дуудлага, мэдээлэл хүлээн авч хуульд заасан журмын дагуу шалгаж шийдвэрлэсэн нь өмнөх оны мөн үеийнхээс 179 буюу 16.5 хувиар өссөн. Үүнээс 347 буюу 27.5 хувь нь гэмт хэргийн шинжтэй, 911 буюу 72.4 хувь нь зөрчлийн шинжтэй гомдол байна.

Гэмт хэргийн шинжтэй гомдол,
мэдээллийн шийдвэрлэлт :

Зөрчлийн шинжтэй гомдол,
мэдээллийн шийдвэрлэлт:




Хүлээн авч шалагасан гомдол, мэдээллээс гэмт хэргийн шинжтэй 57, зөрчлийн шинжтэй 26 нийт 83 буюу 6.6 хувь нь шийдвэрлэгдээгүй, хуулийн хугацаанд шалгагдаж байна.

Гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээллийн 33 буюу 9.5 хувийг 5 хоногт, 257 буюу 74 хувийг 6-19 хоногт, Зөрчлийн шинжтэй гомдол мэдээллийн 875 буюу 96 хувийг 5 хоногт тус тус шалгаж шийдвэрлэсэн.

ХОЁР. БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ

Аймгийн хэмжээнд энэ оны 3 дугаар сард 140 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 19 нэгжээр буюу 15.7 хувиар өссөн.




Энэ хугацаанд хэрэг бүртгэлтийн 77 хэрэг бүртгэгдсэнээс 26 хэргийн холбогдогчийг яллагдагчаар татаж ял сонгосон. Нийт гэмт хэргийн илрүүлэлт 33.8 хувьтай байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 7.5 пунктээр өссөн байна.

Энэ нь хангайн бүсийн 6 аймгийн 7 нэгжтэй харьцуулахад 3 дугаарт, орон нутгийн 29 нэгжтэй харьцуулахад 16 дугаарт байна. Орон нутгаас Хэний аймаг гэмт хэргийн илрүүлэлтээрээ 56.3 хувьтай байгаа нь өндөр үзүүлэлттэй байна.


60.8% буюу **85** нь Баянхонгор сум
39.2% буюу **55** нь бусад сумдад



Гэмт хэргийн гаралтыг багаар нь харьцуулсан байдал




Гэмт хэргийн гаралтыг сумдаар нь харьцуулсан байдал



Бүртгэгдсэн гэмт хэргийн ангилал:


Бүртгэгдсэн гэмт хэргийн 110 буюу 78.5 хувь нь хөнгөн ангилалын, 30 буюу 21.5 хувь нь хүнд ангилалын гэмт хэрэг бүртгэгдсэн.



Нийт бүртгэгдсэн гэмт хэрэг /Эрүүгийн хуулийн бүлгээр/:


Хэргийн ангилал	Өссөн дүнгээр			
	2021 оны 03 сар	2022 оны 03 сар	ᠨᠠᠳᠠᠭᠠᠨ	
			ᠣᠶᠢ	ᠣᠶᠠᠭᠤ
Хүнийг алах	1	1		
Хүнийг амиа хорлох нөхцөл байдалд хүргэх	0	1	1	100%
Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг	56	44	-12	-21.4%
Хүчиндэх	5	6	1	20%
Хулгайлах	14	21	7	50%
Мал хулгайлах	5	24	19	3.8 дахин
Дээрэм	2	2		
Залилах	10	14	4	40%
Хүрээлэн буй орчны эсрэг	7	2	-5	-71.4%
ᠣᠶᠠᠭᠠᠨ	3	4	1	33.3%
Бусад	18	21	3	16.6%

Гэмт хэргийн бүтцэд хамгийн өндөр хувь эзэлж буй гэмт хэргийн төрөл:




■ Өмчлөх эрхийн эсрэг ■ Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг ■ Бусад

Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг



Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг



Гэмт хэрэг үйлдэгдсэн байдал:


Бүртгэгдсэн гэмт хэргийн 45 буюу 32.1 хувь нь согтуугаар, 16 буюу 11.4 хувь нь эмэгтэй хүн оролцож, 14 буюу 10 хувь нь бүлэглэн, 3 буюу 2.1 хувь нь хүүхэд оролцож, 16 буюу 11.4 хувь нь гэр бүлийн хүчирхийллийн улмаас тус тус үйлдэгдсэн байна.




Бүртгэгдсэн гэмт хэргийн үйлдэгдсэн газар, гараг, цаг хугацаа

Баянхонгор аймагт бүртгэгдсэн 140 гэмт хэргээс 46 буюу 32.8 хувь нь гэр орон сууцанд, 20 буюу 14.2 хувь нь гудамж талбайд, 16 буюу 11.4 хувь нь олон нийтийн газар, 4 буюу 2.8 хувь нь авто замд, 5 буюу 3.5 хувь нь тус тус төрийн байгууллага, аж ахуйн нэгжид, 49 буюу 35 хувь нь бусад газарт үйлдэгдсэн байна.

Үйлдэгдсэн гараг:




Үйлдэгдсэн цаг:



Гэмт хэргийн улмаас хохирсон хүн, байгууллага:

Гэмт хэргийн улмаас 135 иргэн хохирч, үүнээс 52 хүн гэмтсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 8 нэгжээр буюу 13.3 хувиар өсч, 2 хүн нас барсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 1 нэгжээр буюу 33.3 хувиар буурсан.




Гэмт хэргийн улмаас 541.5 сая төгрөгийн хохирол учирснаас 145.3 сая төгрөгийг нөхөн төлүүлж, хохирол нөхөн төлүүлэлт 26.8 хувьтай байна.

	2021.03 сар	2022.03 сар	Хохирол	Нөхөн төлүүлэлт	Битүүмжилсэн хөрөнгө
1000	203.3	541.5	82.4	145.3	29.5
2021 оны 3 сар	203.3		82.4		29.5
2022 оны 3 сар		541.5		145.3	23.4

Гэмт хэрэгт холбогдсон хүн:

Энэ хугацаанд нийт 100 хүн шалгагдсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 26 нэгжээр буюу 35.1 хувиар өссөн бөгөөд 16 эмэгтэй хүн холбогдон шалгагдсан нь 77.7 хувиар, 31 хүн урьд ял шийтгэгдсэн нь 1,2 дахин тус тус өссөн.



Нийгмийн байдал



Боловсролоор нь



ГУРАВ: ЗӨРЧИЙН МЭДЭЭ

Аймгийн хэмжээнд 2022 оны 03 дугаар сард нийт 3767 зөрчил шалгасан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 645 зөрчлөөр буюу 14.6 хувиар буурсан. Бүртгэгдсэн зөрчлийн 3703 буюу 98.3 хувийг шийдвэрлэсэн байна.

Бүртгэгдсэн зөрчлөөс 3139 зөрчлийг ердийн журмаар 80010.3 төгрөгөөр, 424 зөрчлийг хялбаршуулан шалгах журмаар 107140.0 мянган төгрөгөөр, зөрчлийн хэрэг нээн шалгасан 18 зөрчлийг 4405.0 мянган төгрөгөөр /нийт торгууль 191555.3/ тус тус торгож шийдвэрлэсэн байна.

Энэ хугацаанд 121 хүнд баривчлах шийтгэл ногдуулсан нь 34 нэгжээр буюу -21.9 хувиар, 194 зөрчлийг торгож, эрх хассан нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 13 нэгжээр буюу 7.2 хувиар өссөн байна.



Зөрчил үйлдэгдсэн онцлог:


Зөрчил үйлдэгдсэн байдал	2021.03	2022.03 сар	/Өсөлт,бууралт/	Хувиар
Согтуугаар	458	456	-2	0.4%
Хүүхэд оролцсон	6	0	-6	-100%
Эмэгтэй хүн оролцсон	25	87	62	2.4 дахин
Гэр бүлийн хүчирхийллийн улмаас	63	63		ижил түвшинд
Олон нийтийн газар	36	27	-9	-25%
Гэр орон сууцанд	175	178	3	1.7%
Гудамж талбайд	470	361	-109	-23.2%

Зөрчил үйлдэгдсэн цаг хугацаа, гарагийг нийт зөрчилтэй харьцуулсан эзлэх хувь:

Зөрчил гарсан цагаар нь:		Зөрчил гарсан өдрөөр нь:	
06-12 цагт	836 буюу 22.2%	Даваа гараг	657 буюу 17.4%
		Мягмар гараг	521 буюу 13.8%
13-18 цагт	1947 буюу 51.7%	Лхагва гараг	572 буюу 15.2%
		Пүрэв гараг	498 буюу 13.2%
19-24 цагт	790 буюу 21%	Баасан гараг	581 буюу 15.4%
		Бямба гараг	490 буюу 13%
01-05 цагт	194 буюу 5.1%	Ням гараг	448 буюу 11.9%

Зөрчил үйлдсэн иргэдийг нийгмийн байдлаар нь авч үзвэл:

Энэ хугацаанд 564 иргэн зөрчилд холбогдон шалгагдсанаас 105 буюу 18.6 хувь нь эмэгтэй, 175 буюу 31 хувь нь малчин болон ажилгүй, 102 буюу 18.1 хувь нь хувиараа хөдөлмөр эрхлэгч, 47 буюу 8.3 хувь нь төрийн албан хаагч эзэлж байгаа нь бусад салбараас өндөр хувийг эзэлж байна.



Шийтгэл ногдуулсан эрх бүхий албан тушаалтнаар нь авч үзвэл:



432 буюу **76.5** хувьд цагдаагийн байгууллагын эрх бүхий алба хаагч




133 буюу **23.5** хувьд шүүгч

Согтууруулах үндэс хэрэглэсэн үедээ гэмт хэрэг, зөрчилд холбогдсон этгээдийг эрүүлжүүлэх, саатуулах үйл ажиллагаа:

Энэ хугацаанд 293 хүн эрүүлжүүлэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 23 нэгжээр буюу 8.5 хувиар өсч, эрүүлжүүлэгдсэн хүний 241 буюу 82.3 хувийг гэр, орон сууцнаас, 27 буюу 9.2 хувийг гудамж талбайгаас, 12 буюу 4.1 хувийг байгууллага, аж ахуйн нэгжээс, 7 буюу 2.4 хувийг үзвэр, үйлчилгээний газраас, 2 буюу 0.7 хувийг зочид буудлаас, 2 буюу 0.7 хувийг бар цэнгээний газраас тус тус эрүүлжүүлэгдсэн байна.

Сүүлийн 5 жилд эрүүлжүүлэгдсэн хүний тоо:



Нийт эрүүлжүүлэгдсэн хүний 279 буюу 95.2 хувь нь эрэгтэй, 14 буюу 4.8 хувь нь эмэгтэй хүн эзэлж байна.

НЭГ: ДҮГНЭЛТ

Аймгийн хэмжээнд 2022 оны 03 дугаар сард бүртгэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн статистик мэдээнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

НЭГ. ХҮЛЭЭН АВСАН ГОМДОЛ, МЭДЭЭЛЛИЙН ТАЛААР:

1.1. Тус цагдаагийн газарт 2022 оны 3 дугаар сард иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй 1258 гомдол, мэдээлэл хүлээн авч шалгасан нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 179 нэгжээр буюу 16.5 хувиар өссөн.

1.2 Баянхонгор аймаг дахь Цагдаагийн газар нь нийт хүлээн авч шалгасан гомдол, мэдээллийн ачааллаар орон нутгийн Цагдаагийн газар, хэлтсийн хэмжээнд ТАВДУГААРТ хангайн бүсийн 6 аймгаас ГУРАВДУГААР эрэмбэлэгдэж байна.

ХОЁР. БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРГИЙН ТАЛААР:

2.1. Баянхонгор аймаг дахь Цагдаагийн газарт 2022 оны 3 дугаар сард нийт 140 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 19 нэгжээр буюу 15.7 хувиар өссөн.

2.2. Бүртгэгдсэн гэмт хэргийн өсөлт, бууралтыг Эрүүгийн хуулийн бүлгээр нь авч үзвэл: Өмнөх оны мөн үетэй харьцуулахад хүнийг амиа хорлох нөхцөл байдалд хүргэх гэмт хэрэг 1 нэгжээр 100 хувиар, хүчиндэх гэмт хэрэг 1 нэгжээр буюу 20 хувиар, хулгайлах гэмт хэрэг 7 нэгжээр буюу 50 хувиар, мал хулгайлах гэмт хэрэг 19 нэгжээр буюу 3.8 дахин, залилах гэмт хэрэг 4 нэгжээр буюу 40 хувиар, хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг 1 нэгжээр буюу 33.3 хувиар, бусад гэмт хэрэг 16.6 хувиар **тус тус өсч**, хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 12 нэгжээр буюу 21.4 хувиар, хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэг 5 нэгжээр буюу 71.4 хувиар **буурсан**.

2.3. Бүртгэгдсэн хэргийн 44 гэмт хэргийн 31.4 хувийг хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг, 69 буюу 49.3 хувийг өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг эзэлж байгаа бөгөөд эдгээр 2 бүлгийн гэмт хэрэг нь нийт хэргийн 80.7 хувийг эзэлж байгаа бөгөөд энэ нь сүүлийн жилүүдэд өсөлттэй байгаа үзүүлэлт юм.

Нийт бүртгэгдсэн гэмт хэргийн 60.7 хувь нь Баянхонгор суманд үйлдэгдэж 82.9 хувиар өссөн нь аймгийн хэмжээнд бүртгэгдсэн гэмт хэрэг 15.7 хувиар өсөхөд шууд нөлөөлсөн.

Мөн зонхилон үйлдэгддэг хулгайлах, мал хулгайлах, залилах болон бусад гэмт хэргүүд өссөн нь нийт хэрэг өсөхөд нөлөөлсөн.

2.4. Нийт гэмт хэргийн гаралтаар орон нутгийн хэмжээнд 2022 оны 3 дугаар сарын байдлаар АРВАНХОЁРДУГААРТ, хангайн бүсийн хэмжээнд ДӨРӨВДҮГЭЭРТ байгаа нь бусад орон нутагтай харьцуулахад эрүү хэв журмын нөхцөл байдал хүнд, алба хаагчид ачаалалтай ажиллаж байна гэж дүгнэхээр байна. Гэмт хэргийн гаралтаар НЭГДҮГЭЭРТ Орхон аймаг 271, ХОЁРДУГААРТ Дорноговь аймаг 252, Өвөрхангай аймаг 249 бүртгэгдэн нь гэмт хэргийн гаралтаар эхний 3 аймагт багтаж байна.

2.5 Мал хулгайлах гэмт хэрэг 3.8 дахин, залилах гэмт хэрэг 40 хувиар өссөн. Тэр дундаа залилах гэмт хэрэг нь цахим орчинд үйлдэгдэх тохиолдол өссөөр байгаа нь онцгой анхаарал татаж байна.

ГУРАВ. ГЭМТ ХЭРГИЙН ИЛРҮҮЛЭЛТИЙН ТАЛААР:

3.1. Гэмт хэргийн илрүүлэлт аймгийн хэмжээнд 33.8 хувьтай байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 7.5 хувиар өссөн байгаа нь цагдаагийн алба хаагчдаас мөрдөн шалгах ажиллагааг үр дүнтэй явуулах, гэмт хэргийг халуун мөрөөр нь илрүүлэх ажиллагаа сайжирсны нэг илрэл юм.

ДӨРӨВ. ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧИЛД ХОЛБОГДОГЧИЙН ТАЛААР:

4.1. Гэмт хэрэг, зөрчилд холбогдогчдийн нийгмийн байдлаар нь авч үзэхэд гэмт хэрэгт холбогдсон иргэдийн 34 буюу 34 хувь нь, гэмт хэрэгт өртөж хохирогчдийн 42 буюу 31.1 хувь нь, зөрчилд холбогдогчийн 175 буюу 31 хувь хувь нь тус тус малчин иргэд байгаа нь тэдний хууль, эрх зүйн мэдлэг, мэдээлэл дутмаг байгаатай холбоотой гэж дүгнэж байна.

Мөн төрийн албан хаагчдаас гэмт хэрэг, зөрчилд холбогдох явдал нь таслан зогсоогдохгүй байгаа тул шийдвэрлэгдсэн тухай бүр нь байгууллагад нь “Албан мэдэгдэл” хүргүүлж, үр дүнг нь тооцож ажиллаж, сахилга ёс зүйг нь сайжруулах шаардлагатай байна.

ТАВ. ЗӨРЧЛИЙН ТАЛААР:

5.1. Аймгийн хэмжээнд 2022 оны 03 дугаар сард нийт 3767 зөрчил шалгасан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 645 нэгжээр буурсан.

Зөрчил гаргасан нийт 3388 иргэнийг 191555.3 төгрөгөөр торгосон. Үүнээс 2804 буюу 82.8 хувийг замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчсөн зөрчил байна.

5.2. Энэ хугацаанд 293 эрүүлжүүлэгдсэн хүн 23 нэгжээр буюу 8.5 хувиар өссөн. Энэ хугацаанд эрүүлжүүлэгдсэн иргэдийн 241 буюу 82.3 хувь нь гэр орон сууцнаас эрүүлжүүлэгдсэн байгаа нь гэр бүл, ахуйн хүрээнд архи, согтууруулах ундааны зүйл хэрэглэх тохиолдол их байгаатай холбоотой байна.

САНАЛ

1. Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг болон гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор “Нэг хором” урьдчилан сэргийлэх нөлөөллийн арга хэмжээг аймгийн ГХУСАЗСЗ болон мэргэжлийн байгууллагуудтай хамтран зохион байгуулах,

2. Согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг, зөрчлийг бууруулах чиглэлээр “Жаргалтай амьдрал” төвтэй хамтран ажиллах, согтуугаар үйлдэгдсэн гэмт хэргийн криминологи судалгааны хүрээнд боловсруулсан зөвлөмжийг хэрэгжүүлэх,
3. Залилах болон цахим орчинд үйлдэгдэж буй гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр иргэдэд чиглэсэн мэдээлэл, сургалтууд, нөлөөллийн ажил арга хэмжээ зохион байгуулах,
4. Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн гэмт хэрэг, зөрчил удаа дараа үйлдэж буй иргэдэд чиглэсэн нэг бүрчилсэн хяналтыг хэрэгжүүлэх,
5. Өмчийн хулгай болон мал хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор “Ноолуур” хэсэгчилсэн арга хэмжээг үр дүнтэй зохион байгуулах,
6. Төрийн албан хаагчдыг гэмт хэрэг, зөрчилд холбогдохоос урьдчилан сэргийлэх зорилгоор “Албан мэдэгдэл” хэсэгчилсэн арга хэмжээг үр дүнтэй зохион байгуулах,
7. Гэмт хэргийн гаралт өсөлттэй байгаа баг, сумдад гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хөдөө сумдын иргэд, малчдыг мэдээллээр хангах, тэдэнд хууль, эрх зүйн мэдлэг олгох зорилгоор сумдад урьдчилан сэргийлэх ажил, сургалт, сурталчилгааг зохион байгуулах,

ТАНИЛЦУУЛГА ГАРГАСАН:

МЭДЭЭЛЭЛ СУДАЛГААНЫ АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН,
ЦАГДААГИЙН ХОШУУЧ

Б.БЯМБАА

ТАНИЛЦСАН:

ДАРГА,
ЦАГДААГИЙН ХУРАНДАА

Б.ОЮУТБОЛД

Орон нутгийн удирдлагатай хамтран малын биед чип суулгах, мөшгөлтийн шинэ аргыг хэрэглэн гар утсаараа малаа хянах төхөөрөмжийн талаар судалж, мэдээллийг малчдад түгээх, алдуул малыг зарлуулах, санамж сэрэмжлүүлгийг тогтмол өгч, харилцан мэдээлэл солилцох сүлжээг идэвхижүүлэх зэрэг ажлыг зохион байгуулах зэрэг саналтай байгааг танилцуулж байна